



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 15 өдөр


Дугаар 434

Улаанбаатар хот

Г
Эмгэг судлалын үндэсний төвийн
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмгэг судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг тус төвийн Захирал (Ч.Батсайхан)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтүяа)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 78 тоот тушаал хүчингүй болсонд тооцсугай.



D:\barimt\tushaal

002855

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмгэг судлалын үндэсний төв нь (цаашид Төв гэх) улсын хэмжээнд эмгэг судлалын төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий лавлагаа төв мөн.
- 1.2. Төв нь эмгэг эд эс, бүтэц судлал, онош зүйн лабораторийн шинжилгээний аргуудад тулгуурлан эмгэг судлалын онош тавьж, эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй эмнэлзүйн эмч нарын оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа явуулах, эмгэг судлаач эмч, лаборант, цогцос задлагч туслах ажилтан нарыг сургаж мэргшүүлэх, эмгэг судлалын тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага, арга зүй, хяналтаар хангах, хөгжлийн хэтийн төлөв, бодлого боловсруулах зорилго бүхий эрдэм шинжилгээ–сургалт–практикийн эрүүл мэндийн байгууллага мөн.
- 1.3. Төв нь эмгэг судлалын чиглэлээр улсын хэмжээнд мэргэжлийн дүгнэлт гаргаж, зөвлөгөө өгөх дээд байгууллага болно.
- 1.4. Төв нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.
- 1.5. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын дагуу явуулна.
- 1.6. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон билэгдэл, санхүүгийн харилцах данстай байна.
- 1.7. Төв нь Эмгэг судлалын үндэсний төв, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-1 хаягтай байна.
- 1.8. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Pathology" гэж нэрлэнэ.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

- 2.1. Төв нь үйл ажиллагаанд даравхар зарчмыг баримтална. Үүнд:
 - Үйлчлүүлэгчийг дээдлэх;
 - Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
 - Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих;
 - Тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
 - Тусlamж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
 - Тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
 - Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
 - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;
- 2.2. Төвийн эрхэм зорилго:
Эмгэг судлалын тусламж үйлчилгээг сайжруулж, оношилгоо, эмчилгээний магадлалыг дээшлүүлэх, эмгэг судлалын шинжилгээнд дэвшилтээ аргыг нэвтрүүлэн, нотолгоо түшсэн оношилгооны чанарыг сайжруулж, эмнэлзүйн эмч нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд оршино.
- 2.3. Төвийн зорилт:
 - Эмгэг судлалын үйл ажиллагааны мэргэжлийн удирдлага, аргазүйг дээшлүүлэх;
 - Эмгэг судлалын шинжилгээ, оношилгоо, үйлчилгээний чанарыг сайжруулах;
 - Эд, эсийн шинжилгээний дэвшилтээ аргуудыг нэвтрүүлэх;

- 142
- Цомхон бүтэц бүхий чадварлаг эмгэг судлаач, лаборант нарын ололт, амжилтад тулгуурлан хөгжилтэй орнуудын жишиг бүхий зохион байгуулалтанд орж, клиникийн эмч нар, ялангуяа эмчилгээний хяналтын албатай нягт хамтран ажиллахыг эрмэлзэх;
 - Аймаг, орон нутагт ажиллаж буй эмгэг судлаач эмч нарыг боловсон хүчний нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд оруулах замаар эмгэг судлаач эмч нарын ажлын чадавхи, үр дүн, хариуцлагыг жигд сайжруулах, эмгэг судлалын албаны нэр хүндийг нэмэгдүүлж, үр өгөөжтэй ажиллах.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй:

3.1.1. Эмгэг судлалын чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм стандарт, эмгэг судлалын удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2.Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.3.Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн эмгэг судлалын тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

3.1.4.Судалгаа, шинжилгээний ажил хийх, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах, оролцох;

3.1.5.Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах;

3.1.6.Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай бодис урвалж, эд, эсийн лабораторийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;

3.1.7.Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу эмгэг судлалын тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.8.Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2. Төв нь дараах үүрэгтэй:

3.2.1. Амьд ахуйн эд, эсийн шинжилгээ, эмгэг судлалын задлан шинжилгээ, эмнэлзүй эмгэг судлалын зөвлөгөөний чиглэлээр лавлагаа тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлэх;

3.2.2. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.3. Эмгэг судлалын чиглэлээр оношилгооны стандарт, эмгэг судлалын удирдамж, аргачлал боловсруулах;

3.2.4. Эмгэг судлалын чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, аймгийн нэгдсэн эмнэлэг, бусийн оношилгоо, эмчилгээний төвийн эмгэг судлалын тасагт мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, ийнхүү сургахад шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх;

3.2.5. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгооны дэвшилтэй техник, технологийг нэвтрүүлэх;

3.2.6. Үрьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх амьд ахуйн эд, эсийн шинжилгээг зохисн байгуулах, холбогдох байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

3.2.7. Эмгэг судлалын чиглэлээр нас баралтыг судлах тогтолцоог бий болгон мэдээний сан бурдүүлж төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;

3.2.8. Үйл ажиллагаандын мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахим бүртгэлийг ашиглах нөхцлийг бурдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.9. Эмгэг судлалын чиглэлээр судалгаа, шинжилгээ гүйцэтгэж, оношилгооны стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;

3.2.10. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;

3.2.11. Үйлчлүүлэгчдийг эмгэг судлалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.12. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бурдүүлэх, санал, гомдолд дүн шинжилгээ хийж запруулах арга хэмжээг үйл ажиллагаанд тусган ажиллах;

3.2.13. Эмгэг судлалын чиглэлээр болон байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний итгэмжлэл авах;

3.2.14. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;

3.2.15. Эмгэг судлалын үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.16. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.17. Ажиллагсдын мэдлэг, үр чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.18. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Дөрөв. Төвийн бүтэц, зохион байгуулалт

4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Захирал, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бурдэнэ.

4.2. Төвийн Захирал нь дэд захирал, тасаг, лабораторийн эрхлэгч, судалгаа шинжилгээ, сургалт, технологийн албаны дарга, стратеги төлөвлөлт, гадаад харилцааны албаны дарга болон захиргааны нэгжийн удирдлагуудыг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4.3. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа, шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Захирал батална.

4.4. Төвийн Захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

4.5. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон бусад шаардлагатай хороод байгуулан ажиллуулна.

4.6. Захирлын эрх, үүрэг:

4.6.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

4.6.2. Төвийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ойрын болон хэтийн хөгжлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;

4.6.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

4.6.4. Дэд захирал, албаны дарга, тасгийн эрхлэгч нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

- 14
- 4.6.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;
- 4.6.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;
- 4.6.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;
- 4.6.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид, ажиллах;
- 4.6.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах.

Тав. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1. Улсын төсөв;
- 5.2. Үндсэн (эд, эсийн шинжилгээний төлбөртэй үйлчилгээний орлого, үйлчлүүлэгчийн захиалгаар хийх урьдчилан сэргийлэх эд, эсийн шинжилгээ) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хууль тогтоомжинд нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлого гэх мэт);
- 5.3. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;
- 5.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.5. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

- 6.1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Захирал төлөөлнө.
- 6.2. Төвийн Захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Захирал шийдвэрлэнэ.
- 6.4. Төв нь төрийн захирагааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.
- 6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. Төвийн Дэд захирал, албадын ерөнхий чиг үүрэг

7.1. Дэд захирал

Эмгэг судлалын тусламж үйлчилгээг үйлчлэх хүрээний эмнэлгүүдэд чанарын өндөр түвшинд үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, аймаг, орон нутгийн эмгэг судлалын тасгийг мэргэжлийн арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах, эмгэг судлаач эмч нарын мэргэжил, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана.

7.2. Эд, эсийн лавлагаа лаборатори

7.2.1. Төвийн Эд, эсийн лавлагаа лаборатори нь Улаанбаатар хот, аймаг орон нутгийн эмгэг судлалын тусламж, үйлчилгээ, лабораторийн шинжилгээ, оношилгоонд стандартын дагуу хяналт тавих, мэргэжил, арга зүйн заавар зөвлөгөө өгөх, задлан шинжилгээ, амьд ахуйн эд, эсийн шинжилгээнд гистохими, иммуногистохимийн будгийн аргуудыг ашиглаж дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.2.2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвийн дэргэдэх Төвийн тасаг,

145

лабораториуд нь үйлчлэх хүрээний эмнэлгийн нас баарлтад эмгэг судлалын задлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, эмнэлзүй, эмгэг судлалын эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийх, задлан шинжилгээний дээж материал, амьд ахуйн эд, эсийн шинжилгээнд оношилгоо, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Төвийн I тасаг (Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дэргэд байрлана): Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Арсыны өвчин судлалын үндэсний төв, Сүхбаатар, Чингэлтэй, Налайх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Энэрэл эмнэлэг, бусад эмнэлгүүд;
- Төвийн II тасаг (Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байрлана): Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, I, II, III амаржих газар, Хүүхдийн төв сувилал, бусад эмнэлгүүд;
- Төвийн III тасаг (Улсын гуравдугаар төв эмнэлгийн дэргэд байрлана): Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, бусад эмнэлгүүд;
- Төвийн IV тасаг (Хавдар судлалын үндэсний төвийн дэргэд байрлана): Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, бусад эмнэлгүүд.

7.3. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанарын алба

Эрүүл мэндийн багц хууль, Эрүүл мэндийн сайдын болон Төвийн захирлын баталсан тушаал, шийдвэр, албан даалгавар, заавар, дүрэм, журмыг баримталж ажиллана. Эмгэг судлаач эмч нарын эмгэг судлалын протоколын бичилт, амьд ахуйн эд, эсийн шинжилгээний онош, дүгнэлт, лаборант нарын бичиг баримтын хөтлөлт, гистологи бэлдмэлийн чанар болон эмнэлгийн бусад ажилтнуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эмгэг судлалын тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, санал боловсруулан ажиллана.

7.4. Санхүү бүртгэлийн алба

Төвийн нягтлан бодох бүртгэлийг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөх байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцүүлэн, харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн, зөв мэдээллээр удирдлагыг хангаж ажиллана. Санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайллагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.5. Судалгаа шинжилгээ, сургалт, технологийн алба

7.5.1. Төвийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг манлайлан зохион байгуулах, нас бааралтын түвшин, өвчлөлийн тархалтыг тогтоох тандалт судалгаа хийх, эд, эсийн шинжилгээгээр эрт илрүүлгийг хийх, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байран дахь болон эрүүл мэндийн чиглэлээр эмч мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын байгууллагуудтай гэрээний үндсэн дээр сургалт зохион байгуулах арга хэмжээг хариуцна.

7.5.2. Эмгэг судлалын чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, мэдээний сан үүсгэх, олон улсад нэвтрэх буй анагаах ухааны оолот, амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах асуудлыг эрхэлнэ.

146

7.5.3. Эмгэг судлалын үндсэн үзүүлэлт (эмгэг судлалын задлан шинжилгээ, оношийн зөрөө, эмчилгээ, үйлчилгээний дутагдал, амьд ахуйн эд, эсийн шинжилгээ гэх мэт)-ийн статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцна. Харьяа байгууллага, нэгжүүдийн бүртгэл, мэдээллийн байдалд хяналт тавих, сургалт хийх, цахим бүртгэл, бодит мэдээллийг нэвтрүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.6. Стратеги төлөвлөлт, гадаад харилцааны алба

7.6.1. Төвийн алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, уг стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд ирэх жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн теслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах, байгууллагын дотоод журам, эрсдэлийн үеийн журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дээрх чиглэлээр байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.6.2. Төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, эмгэг судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

7.6.3. Төвийн хөгжил, оношилгооны дэвшилтээг арга, технологийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах тесэл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах, харилцан туршлага солилцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох, өөрийн оронд зохион байгуулах, арга хэмжээ авна.

7.7. Хангамж, үйлчилгээ, инженер технологийн хэлтэс


Төвийн барилга, эд хогшил, автомашин, тоног төхөөрөмж, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тасаг, лабораториудад аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хийх, эмнэлгийн багаж хэрэгсэл, зөөлөн эдлэлийн, ариутгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах ажиллагааг хариуцна.

Найм. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Төвийн Захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

Мэргэжил, арга зүйгээр хангах ерөнхий зураглал

147



- Мэргэжил, арга зүйн шууд удирдлага
- > Мэргэжил, арга зүйн шууд бус удирдлага

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
... сарын 25. өдлийн №34 дугаар
тушаалын хоёрдугаар хувсралт

Эмзэг судлалын үндэсний төвийн бүтэц

